



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХАН-УУЛ ДҮҮРЭГ 2018 ОНД

(Албан ёсны болон захиргааны статистик мэдээллээр бэлтгэх жилийн танилцуулга)



Улаанбаатар хот
2019 он

СТАТИСТИК

хөгжилд хөтлөх хүч

Танилцуулгыг хянасан:

Статистикийн хэлтсийн дарга:

О.Гэрэл

Танилцуулгыг нэгтгэсэн:

Б.Энхжаргал

Хаяг: ХУД, Чингисийн өргөн чөлөө, 3-р хороо Иргэдэд үйлчлэх төв байр

Мэдээллийн үйлчилгээ

Утас: 11-341136

11-343040

Цахим хуудас: www.nso.mn
www.1212.mn
www.ubstat.mn

Цахим хаяг: han-uul@nso.mn



Статистикийн сар бүрийн танилцуулгыг
эндээс татаж авна уу.

АГУУЛГА

1		Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж	1
2		Хүн ам, өрхийн үзүүлэлт	2
3		Хүн амын ажил эрхлэлт	13
4		Нийгмийн даатгал	17
5		Боловсрол	20
6		Эрүүл мэнд	25
7		Дүүргийн аюулгүй байдал	28
8		Хэрэглээний үнэ	38
9		Хөдөө аж ахуй	41
10		Газар тариалан	49
11		Дүүргийн авто машин	51
12		Дүүргийн барилгажилт	53
13		Аж ахуйн нэгж байгууллага	56



НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Хан-Уул дүүрэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын баруун урд хэсэгт дархан цаазат Богд хан уулын ар хормой, Туул голын савд 50.3 мянган га нутаг дэвсгэрийг эзэлж оршдог. Тус дүүрэг нь 2018 оны байдлаар 16 хороо, 48.9 мянган өрхийн 178.9 мянган хүн амтай.


Хүснэгт 1. Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж

Хороо	Нутаг Дэвсгэрийн хэмжээ ¹ (км ²)	Хүн амын нягтрал (1 км ² -д ногдох хүн)
1-р хороо	0.3	34667
2-р хороо	1.4	9986
3-р хороо	4.5	4138
4-р хороо	36.3	326
5-р хороо	1.5	3786
6-р хороо	0.9	7465
7-р хороо	1.1	4285
8-р хороо	45.2	245
9-р хороо	4.2	2221
10-р хороо	32.6	406
11-р хороо	34.2	577
12-р хороо	57.1	104
13-р хороо	125.7	32
14-р хороо	153.1	35
15-р хороо	3.1	8195
16-р хороо	2.3	5595
Дүн	503.5	355

Газрын нэгдмэл сан нь шинэчлэн найруулсан Монгол Улсын газрын тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу үндсэн 6 санд хуваагдаж байна.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн газрын нэгдмэл сан нийт 50351 га байна. Үүнээс: хөдөө аж ахуйн газар 22451.12 га (44.6%), хот тосгон бусад суурин газар 7088.18 га (14.1%), зам шугам сүлжээний газар 2960.3 га (5.9%), ойн сан бүхий газар 2098.0 га (4.2%), усан сан бүхий газар 975.0 га (1.9%), улсын тусгай хэрэгцээний газар 14779.0 га (29.3%)-ийг тус тус эзэлж байна.

Зураг 1. Газрын нэгдмэл сан1



Нийт 50351 га газраас иргэний гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилсөн нийт 822.2 га, иргэний гэр хорооллын эзэмшилд нийт 1142.7 га, төрийн байгууллагын эзэмшилд нийт 245.3 га, аж ахуйн нэгжийн эзэмшилд 1775.2 га, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн ашиглалтанд 55.7 га, хөдөө аж ахуйн эзэмшил, ашиглалтанд нийт 958.5 га, хот тосгон бусад суурин газрын эзэмшил, ашиглалтанд нийт 2878.2 га тус тус байна.



ХҮН АМ, ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2018 оны жилийн эцсийн байдлаар Хан-Уул дүүрэгт 48940 өрхийн 178919 хүн байнга оршин сууж байна. Нийт хүн амын 85457 нь эрэгтэйчүүд (47.8%), 93462 нь (52.2%) эмэгтэйчүүд эзэлж байна.


Хүснэгт 2. Суурин хүн амын тоо, хороогоор

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	127477	131097	138368	150946	159465	169726	178919
1-р хороо	8968	9014	9498	9113	9448	10286	10400
2-р хороо	8956	9113	9530	10549	11400	12120	13981
3-р хороо	10938	10888	12240	13929	15213	16904	18623
4-р хороо	7314	8022	9171	9466	10273	10842	11851
5-р хороо	6186	6244	6052	5975	6002	5955	5679
6-р хороо	7797	6500	6805	6508	7060	6796	6719
7-р хороо	5494	4994	5008	4619	4733	5009	4714
8-р хороо	11504	11268	11030	11266	11420	11336	11082
9-р хороо	7529	8604	8515	9235	9391	9162	9330
10-р хороо	8577	8885	9011	9304	10174	12264	13231
11-р хороо	10143	10879	11341	14640	15098	17161	19740
12-р хороо	5915	5940	6019	5897	6067	5937	5924
13-р хороо	4120	4125	3937	4041	4107	4073	4025
14-р хороо	3751	4123	4329	4710	4884	5105	5345
15-р хороо	12025	14054	17126	20468	22229	23864	25406
16-р хороо	8260	8444	8756	11226	11966	12912	12869
Нийслэлийн дүн	1226991	1267024	1314486	1345500	1380792	1417396	1444669
Нийслэлийн дүнд эзлэх хувь	10.4	10.4	10.5	11.2	11.5	12.0	12.4

Нийслэл хотод оршин суугаа нийт хүн амын 12.0 хувь нь Хан-Уул дүүргийн хүн ам эзэлж байна. Хүн амын нягтралаар авч үзвэл, Хан-Уул дүүргийн нэг км² нутаг дэвсгэрт 2012 онд 263 хүн оршин сууж байсан бол 2013 онд 270 хүн, 2016 онд 317 хүн, 2017 онд 337 хүн оршин суух болжээ.

Дүүргийн хүн ам 2018 онд 178919 болж, өнгөрсөн онтой харьцуулахад 9.2 мянган хүнээр (5.4%) өссөн байна.

Зураг 2. Хүн амын жилийн дундаж өсөлт



Хүснэгт 3. Жилийн эцсийн суурин хүн ам

Он	Жилийн эхний хүн ам	Төрсөн хүүхэд	Нас барсан хүн	Шилжин ирсэн хүн	Шилжин явсан хүн	Жилийн эцсийн хүн ам
2009	98815	2654	618	8353	5038	104166
2010	104166	2657	683	10827	7111	112055
2011	112055	3112	770	9622	4176	119843
2012	119843	3471	761	8420	2434	127477
2013	127477	3999	678	9823	7014	131097
2014	131097	4450	835	12732	6738	138368
2015	138368	4921	700	13695	7453	150946
2016	150946	4969	779	12043	7140	159465
2017	159465	4796	850	12338	7577	169726
2018	169726	4918	829	946	914	178919

Хүн амын өсөлт нь төрөлт болон нас баралтын зөрүүгээр тодорхойлогдох ердийн цэвэр өсөлт, шилжин ирэлт, шилжин явалтын зөрүүгээр тодорхойлогдох механик цэвэр өсөлт гэсэн үндсэн бүрэлдэхүүн хэсгээс тогтдог.

Хүснэгт 4. Дүүргийн хүн амын ердийн болон механик өсөлт

Он	Шилжин ирсэн хүн	Шилжин явсан хүн	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент	Төрсөн хүүхэд	Нас барсан хүн	Ердийн цэвэр өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент
2009	8353	5038	3315	32.6	2654	618	2036	20.0
2010	10827	7111	3716	34.3	2657	683	1974	18.2
2011	9622	4176	5446	46.9	3112	770	2342	20.2
2012	8420	2434	5986	48.4	3471	761	2710	21.9
2013	9823	7014	2809	21.7	3999	678	3321	25.7
2014	12732	6738	5994	44.5	4450	835	3615	26.8
2015	13695	7453	6242	43.1	4921	700	4221	29.2
2016	12043	7140	4903	31.6	4969	779	4190	27.0
2017	12338	7577	4761	28.9	4796	850	3946	24.0
2018	946	914	32	0.2	4918	829	4089	23.4

Төрөлтийн ерөнхий коэффициент 23.4 байгаа нь 1000 хүн тутамд 23 хүүхэд шинээр төрсөн байгааг харуулж байна. 2018 онд 4918 хүүхэд шинээр мэндэлсэнээс 2493 (50.7%) нь хүү, 2425 (49.3%) нь охин байна.

Хүүхэд төрүүлсэн эхийн насны бүлгээр авч үзвэл 19 хүртэлх настай 2.5 хувь, 20-24 настай 15.0 хувь, 25-29 настай 32.8 хувь, 30-34 настай 29.6 хувь, 35-39 настай 15.3 хувь, 40-44 настай 4.5 хувь, 45-аас дээш настай 0.3 хувийг түс түс эзэлж байна.

Нийт амаржсан эхийн 3591 (73.0%) нь магистр болон дээд боловсролтой, 78 (1.6 %) нь техник болон тусгай мэргэжлийн, 1180 (24.0%) нь бүрэн дунд, 51 (1.0%) нь суурь, 4 (0.1%) нь бага боловсролтой, боловсролгүй 13 (0.3%) хүн байна.

2018 онд нас барсан хүний тоо өмнөх оноос 21 хүнээр (2.5%) буурсан байна.

Хүснэгт 5. Гэрлэлт, цуцлалтын тоо

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Гэрлэлт	549	656	766	992	984	865	938	1380
Цуцлалт	242	248	261	281	297	279	250	315

Нийт цуцлалтын гэр бүл байсан хугацаагаар авч үзвэл 8.0 хувь нь гэрлээд 1-3 жил, 60.3 хувь нь 4-14 жил, 31.7 хувь нь 15-аас дээш жил болоод гэрлэлтээ цуцлуулсан байна.


Хүснэгт 6. Гэрлэлт, цуцлалтын ерөнхий, тусгай коэффициент

Он	Хүн амын жилийн дундаж тоо	15 ба түүнээс дээш хүн амын тоо	Гэрлэлтийн тоо	Гэрлэлтийн ерөнхий коэффициент	Гэрлэлтийн тусгай коэффициент	Салалтын тоо	Салалтын ерөнхий коэффициент	Салалтын тусгай коэффициент
2017	164596	115342	938	5.7	8.1	250	1.5	2.2
2018	174323	119566	1380	7.9	11.5	315	1.8	2.6

Гэрлэлтийн ерөнхий коэффициентийг харвал 1000 хүн тутмын 8 нь, гэрлэлтийн тусгай коэффициентээс бол 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутмын 11 нь шинээр гэр бүл болж байна.

Салалтын ерөнхий коэффициентийг харвал 1000 хүн тутмын 2 нь, салалтын тусгай коэффициентээс бол 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутмын 2 нь гэр бүлээ цуцлуулж байна.

Зураг 3. Гэрлэлт, гэр бүл цуцлалт



2018 онд 1380 хос гэрлэлтээ бүртгүүлсэн нь өмнөх оноос 47.1 хувиар өссөн ба 315 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 26.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 7. Үрчлэгдсэн хүүхдийн тоо

Үрчлэгдсэн хүүхдийн тоо	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	69	77	72	73	75	72	81	84
Нийслэлийн дүн	667	607	501	642	649	639	709	669

2018 онд 84 хүүхэд үрчлэгдсэнээс 44 (52.4%) нь эрэгтэй хүүхэд байна. Хүүхдийн насны ангилалаар авч үзвэл 3 хүртэлх насны хүүхэд 16, 3-6 насны хүүхэд 27 хүүхэд, 7-9 насны 10 хүүхэд, 10 түүнээс дээш насны 31 хүүхэд үрчлэгдсэн байна.

Хүснэгт 8. Хүн амын дундаж наслалт


	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улаанбаатар	69.48	70.23	70.65	71.24	71.79	71.47	71.51	71.65
Улсын дундаж	68.32	68.71	69.11	69.57	69.89	69.57	69.89	70.19

Хүснэгт 9. Дүүргийн суурин хүн амын нас, хүйсийн бүтэц

Насны бүлэг	2014		2015		2016		2017		2018	
	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй	бүгд	эмэгтэй
Бүгд	138368	71835	150946	78541	159465	83644	169726	89123	178919	93462
0-4	16971	8382	22647	11091	22479	10950	24117	11711	24799	12194
5-9	11666	5714	15135	7462	16918	8352	18986	9331	21389	10472
10-14	8311	4119	9492	4640	10043	4856	11281	5532	13165	6461
15-19	8706	4414	9376	4732	9446	4777	9385	4689	9881	4892
20-24	12214	6377	11133	5937	10935	5789	10259	5460	10194	5327
25-29	16359	8548	16658	8863	17242	9311	17564	9640	16114	8924
30-34	13471	7049	14209	7563	15993	8523	17835	9578	18854	10034
35-39	11444	5980	11725	6136	12789	6885	13951	7456	14776	7818
40-44	9942	5148	10210	5282	11236	5992	11654	6275	12352	6517
45-49	8448	4446	8327	4334	8586	4514	9342	4881	10069	5198
50-54	7122	3913	7450	4078	7832	4368	7934	4406	8333	4538
55-59	4874	2659	5518	3044	6005	3400	6576	3805	7231	4092
60-64	2998	1691	3167	1839	3679	2092	3999	2313	4598	2596
65-69	2079	1231	2266	1361	2320	1415	2691	1485	2713	1648
70+	3763	2164	3633	2179	3962	2420	4152	2561	4451	2751

Хан-Уул дүүргийн нийт хүн амын 64.0 хувь нь 35 хүртэл насны хүүхэд, залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын 61364 (34.3%) нь 0-15 насны хүүхэд, 105793 (59.1%) нь 16-59 насны хүмүүс, 11762 (6.6%) нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан байна.

Зураг 4. Хүн амын нас, хүйсийн суварга 2018 он



Хүснэгт 10. Дүүргийн хүн амын хүйсийн харьцаа, насны бүлгээр

Насны бүлэг	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	89.6	89.1	90.6	92.6	92.2	90.6	90.4	91.4
0-4	101.8	100.7	107.0	102.5	104.2	105.3	105.9	103.4
5-9	106.1	102.4	106.1	104.2	102.8	102.6	103.5	104.2
10-14	99.1	97.2	98.7	101.8	104.6	106.8	103.9	103.8
15-19	95.5	95.9	95.1	97.2	98.1	97.7	100.1	102.0
20-24	85.3	87.2	91.5	91.5	87.5	88.9	87.9	91.4
25-29	82.3	87.7	87.3	91.4	87.9	85.2	82.2	80.6
30-34	86.0	87.9	86.5	91.1	87.9	87.6	86.2	87.9
35-39	89.1	87.8	88.7	91.4	91.1	85.8	87.1	89.0
40-44	87.7	84.8	89.4	93.1	93.3	87.5	85.7	89.5
45-49	86.0	81.5	81.0	90.0	92.1	90.2	91.4	93.7
50-54	86.0	76.2	76.1	82.0	82.7	79.3	80.1	83.6
55-59	80.7	82.7	85.3	83.3	81.3	76.6	72.8	76.7
60-64	76.8	77.0	75.2	77.3	72.2	75.9	72.9	77.1
65-69	82.0	74.4	72.5	68.9	66.5	64.0	81.2	64.6
70+	77.9	77.6	74.6	73.9	66.7	63.7	62.1	61.8


Дүүргийн хүн амын хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 91.4 буюу 91 эрэгтэй ногдож байна. Насны бүлгээр 0-14 насанд 100 эмэгтэй хүүхдэд ногдох эрэгтэй хүүхдийн тоо давамгайлж байгаа боловч нас ахих тусам 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо цөөрч байна.

Хүснэгт 11. Хүн ам зүйн ачаалал, хороогоор

Хороо	Хүн ам зүйн ачаалал					
	2013	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	47.9	44.8	54.4	53.7	56.4	59.2
1-р хороо	63.8	56.7	72.4	59.4	59.0	63.0
2-р хороо	41.3	42.5	60.1	53.2	56.4	60.7
3-р хороо	57.2	56.0	63.6	56.7	59.5	62.9
4-р хороо	46.5	25.7	55.1	52.1	53.3	56.7
5-р хороо	49.8	53.8	62.4	49.4	53.4	52.0
6-р хороо	51.0	50.9	57.4	46.5	48.4	50.3
7-р хороо	52.3	49.3	58.2	50.6	49.4	53.1
8-р хороо	47.4	50.6	57.3	49.4	50.1	52.4
9-р хороо	54.5	54.8	62.2	53.5	54.7	55.0
10-р хороо	49.4	51.3	61.8	52.5	56.4	63.1
11-р хороо	49.0	55.1	61.3	54.9	56.5	58.7
12-р хороо	54.9	57.3	63.1	54.3	57.3	59.1
13-р хороо	68.0	58.2	63.4	54.3	55.8	57.3
14-р хороо	65.1	67.5	73.4	55.8	58.7	59.9
15-р хороо	48.2	67.7	69.1	55.6	62.6	63.4
16-р хороо	42.9	45.9	63.1	54.6	56.8	60.2
Нийслэлийн дундаж	44.4	44.6	50.4	49.9	51.3	54.9

Хүн ам зүйн ачааллыг 0-14 насны хүүхэд болон 65, түүнээс дээш насны өндөр настан хүн амын нийлбэрийг 15-64 насны хүн амд харьцуулж тооцох ба 2018 оны байдлаар 59.2 хувь болж 2016 оноос 2.8 пунктээр өссөн байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн бүр 59 хүнийг тэжээж байгаа болно.

Зураг 5. Хүн ам зүйн ачаалал 2018 он, хороогоор



ДҮҮРГИЙН ӨРХ, НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Хан-Уул дүүрэгт 2018 оны жилийн эцэст нийслэлийн нийт өрхийн 48940 өрх (12.6%) оршин сууж байна. Өрхийн тоо 2017 оноос 1738 өрхөөр (3.7%) өссөн байна.

Хүснэгт 12. Дүүргийн өрхийн тоо, хороогоор

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	33982	35349	39189	43280	45200	47202	48940
1-р хороо	2328	2256	2299	2276	2312	2401	2398
2-р хороо	2454	2467	2687	2670	2750	3068	3371
3-р хороо	2820	3177	3420	3918	4379	4674	4956
4-р хороо	1843	1927	2373	2982	3224	3407	3737
5-р хороо	1508	1522	1573	1564	1532	1478	1462
6-р хороо	1785	1791	1959	1959	1943	1864	1929
7-р хороо	1404	1400	1408	1411	1412	1458	1486
8-р хороо	2923	3014	3129	3345	3351	3243	3190
9-р хороо	2106	2161	2292	2465	2526	2357	2446
10-р хороо	2170	2181	2210	2432	2626	3224	3544
11-р хороо	2526	2713	3254	3910	4144	4691	5100
12-р хороо	1782	1785	1794	1806	1792	1729	1690
13-р хороо	1305	1310	1371	1447	1403	1402	1374
14-р хороо	1288	1403	1481	1666	1644	1725	1826
15-р хороо	3740	4142	5539	6052	6670	6846	6825
16-р хороо	2000	2100	2400	3377	3492	3635	3606
Нийслэлийн дүнд эзлэх хувь	10.7	10.6	11.1	11.5	11.9	12.2	12.6

Хан-Уул дүүргийн хэмжээнд 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй 1750 хүн байгаагийн 49.8 хувь нь 3 хүртэлх хүүхэдтэй, 48.8 хувь нь 3-5 хүүхэдтэй, 1.4 хувь нь 6 ба түүнээс дээш хүүхэдтэй байна.

Ганц бие өндөр настай 513, тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй өндөр настан 13 хүн байна.

Хүснэгт 13. Нэг өрхийн ам бүлийн тоо, дүүргээр

Дүүрэг	2018 оны өрхийн тоо	Нэг өрхийн ам бүлийн тоо					
		2010	2012	2014	2016	2017	2018
Багануур	8569	3.7	3.5	3.4	3.4	3.4	3.4
Багахангай	1272	3.5	3.5	3.6	3.5	3.4	3.5
Баянгол	59536	3.9	3.9	3.8	3.7	3.8	3.8
Баянзүрх	95714	3.8	3.9	3.6	3.5	3.5	3.6
Налайх	10606	3.6	3.6	3.5	3.5	3.5	3.5
Сонгинохайрхан	84236	4.3	4.0	3.8	3.7	3.7	3.8
Сүхбаатар	38563	3.8	3.7	3.8	3.6	3.6	3.8
Хан-Уул	48940	3.7	3.8	3.5	3.5	3.6	3.7
Чингэлтэй	40017	4.2	4.1	4.0	3.9	3.9	3.9
Нийслэлийн дүн	387453	3.9	3.9	3.7	3.6	3.7	3.7

Нэг өрхийн дундаж ам бүлийн тоо Чингэлтэй дүүрэгт их буюу 3.9 хүн, Багануур дүүрэгт хамгийн цөөн буюу 3.4 хүн, бусад дүүрэгт 3.5 - 3.8 хүн байна.

Хүснэгт 14. Өрх толгойлсон, гэр бүлгүй хүний тоо, хүйсээр, хороогоор


Хороо	2014		2015		2016		2017		2018	
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм
Дүүргийн дүн	396	2423	425	2446	433	2657	435	2435	417	2467
1-р хороо	73	228	82	210	71	217	60	137	51	129
2-р хороо	25	185	45	219	44	250	31	211	23	250
3-р хороо	12	61	9	52	15	56	15	53	11	122
4-р хороо	15	121	15	115	17	230	24	152	11	149
5-р хороо	47	229	47	215	47	214	55	255	35	259
6-р хороо	28	322	26	314	28	292	8	272	47	276
7-р хороо	10	186	16	207	33	206	29	205	33	195
8-р хороо	38	163	35	159	36	161	41	172	38	185
9-р хороо	28	201	28	204	28	205	32	215	24	197
10-р хороо	10	142	10	142	11	192	21	91	23	100
11-р хороо	16	102	17	104	17	107	18	117	18	117
12-р хороо	23	123	20	120	10	120	10	122	11	122
13-р хороо	19	65	10	44	5	65	5	58	6	58
14-р хороо	5	18	5	50	3	29	11	36	8	40
15-р хороо	42	81	54	92	58	105	63	121	54	138
16-р хороо	5	196	6	199	10	208	12	218	24	130
Нийслэлийн дүнд эзлэх хувь	9.2	10.6	11.5	11.6	11.4	12.9	12.5	12.8	14.7	14.6

2018 оны жилийн эцэст өрх толгойлсон, гэр бүлгүй 2884 хүн байгаагийн 85.5 хувийг нь өрх толгойлсон эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оноос 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 15. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, хороогоор

Хороо	2015		2016		2017		2018	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
Дүүргийн дүн	3670	1822	3861	1921	3899	1834	3930	1749
1-р хороо	159	77	192	98	231	94	205	72
2-р хороо	192	98	241	142	153	85	192	84
3-р хороо	295	136	297	138	294	135	312	91
4-р хороо	232	108	285	130	293	130	254	118
5-р хороо	213	102	217	104	238	96	218	99
6-р хороо	330	170	338	164	336	172	318	154
7-р хороо	206	89	212	90	169	74	202	93
8-р хороо	352	178	364	223	397	192	395	199
9-р хороо	263	147	271	153	277	143	270	137
10-р хороо	286	172	231	113	253	143	246	121
11-р хороо	173	94	155	79	139	47	198	65
12-р хороо	237	112	232	109	240	114	212	95
13-р хороо	156	57	144	61	157	65	159	77
14-р хороо	171	69	182	72	184	78	173	69
15-р хороо	136	79	198	94	216	104	278	135
16-р хороо	269	134	302	151	322	162	298	140
Нийслэлийн дүнд эзлэх хувь	10.8	11.7	11.4	12.1	11.4	11.5	11.0	11.0

Зураг 6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шалтгаанаар




2018 оны жилийн эцэст 3930 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байгаа нь өмнөх оноос 31 хүнээр (0.8%) өссөн. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэний 44.5 хувь нь эмэгтэй, 13.0 хувийг 0-17 насны хүүхэд эзэлж байна.

Хүснэгт 16. Өнчин хүүхдийн тоо, хороогоор

Хороо	Бүтэн өнчин хүүхдийн тоо					Хагас өнчин хүүхдийн тоо				
	2014	2015	2016	2017	2018	2014	2015	2016	2017	2018
Дүүргийн дүн	152	166	160	164	150	1246	1330	1400	1457	1436
1-р хороо	8	10	10	8	6	33	39	35	49	43
2-р хороо	11	10	14	10	10	60	65	51	41	41
3-р хороо	5	6	8	10	10	77	65	67	63	82
4-р хороо	10	25	13	15	14	65	87	141	174	153
5-р хороо	13	14	12	12	10	122	112	115	75	52
6-р хороо	12	6	6	7	5	70	80	107	110	119
7-р хороо	8	7	6	5	2	61	76	78	118	133
8-р хороо	25	25	22	15	15	161	165	161	188	181
9-р хороо	8	10	18	20	18	108	135	117	92	98
10-р хороо	6	6	8	9	7	55	55	71	58	74
11-р хороо	11	8	7	5	8	95	105	75	77	79
12-р хороо	9	7	9	10	10	78	70	75	81	82
13-р хороо	3	9	7	12	9	44	41	41	51	51
14-р хороо	3	4	4	6	5	53	56	69	62	67
15-р хороо	4	2	4	7	6	19	26	32	38	30
16-р хороо	16	17	12	13	15	145	153	165	180	151
Нийслэлийн дүнд эзлэх хувь	8.9	9.8	10.2	11.0	10.7	10.6	11.7	12.2	12.9	12.3

Зураг 7. Хагас, бүтэн өнчин хүүхдийн тоо



Нийт өнчин хүүхдийн 9.5 хувь нь бүтэн өнчин, 90.5 хувь нь хагас өнчин хүүхэд байна.

Үүнээс 0-4 насны хүүхэд 9.0 хувийг, 5-9 насны хүүхэд 24.1 хувийг, 10-14 насны хүүхэд 36.0 хувийг, 15 настай хүүхэд 11.0 хувийг, 16 настай хүүхэд 11.2 хувийг, 17 настай хүүхэд 8.7 хувийг эзэлж байна.

Дүүргийн сууцны нөхцөл:


2018 оны байдлаар дүүргийн нийт өрхийн 43.6 хувь нь гэр хороололд, 56.4 хувь нь орон сууцны хороололд оршин сууж байна. Хан-Уул дүүргийн гэр хороололд амьдардаг өрх, хүн амын тоо 2008 оноос эхлэн нэмэгдэж, 2011 оны байдлаар нийт өрхийн 58.7 хувь, 2012 онд 57.0 хувь, 2013 онд 56.4 хувь, 2014 онд 51.9 хувь, 2015 онд 50.1 хувь, 2016 онд 48.0 хувь, 2017 онд 45.5 хувь, 2018 онд 43.6 хувь нь гэр хороололд амьдарч байна.

Хүснэгт 17. Орон сууцны болон сууцны тусдаа байшин, гэрт амьдардаг өрхийн судалгаа

Үзүүлэлт		2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийт өрхийн тоо		33982	35349	39189	43280	45200	47202	48940
Үүнээс:	Орон сууцны хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	14610	15425	18853	21612	23508	25723	27601
	нийтийн орон сууцны тусдаа тохилог орон сууц	14326	15064	18473	21035	22912	25092	26835
	орон гэргүй	284	358	380	571	591	626	761
	Орон гэргүй	-	3	-	6	5	5	5
	Гэр хорооллын өрхийн тоо бүгд, үүнээс:	19372	19924	20336	21668	21692	21479	21339
	тохилог орон сууцанд	175	149	155	377	418	363	341
	байшинд амьдардаг	12574	12587	12674	11664	11453	11805	11277
	монгол гэрт амьдардаг	6597	7150	7486	9613	9805	9296	9705
	орон гэргүй	26	38	21	14	16	15	16
	Орон сууцны хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	41.3	42.9	43.6	48.1	49.9	52.0	56.4
	Гэр хороололд амьдарч буй өрхийн эзлэх хувь	58.7	57.0	56.4	51.9	50.1	48.0	43.6

Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт орон сууцны барилгууд ихээр нэмэгдэж, 2012 оноос орон сууцны хорооллын өрхийн тоо 14958 өрхөөр нэмэгдсэн хэдий ч нийслэл хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс шууд шалтгаалж гэр хорооллын өрх, хүн амын тоо буурахгүй байна.

Зураг 8. Дүүргийн өрх, хороололор




2018 онд орон сууцны хорооллын өрхийн тоо 27601 болж, өнгөрсөн онтой харьцуулахад 1878 өрх (7.3%) өссөн байна. Орон сууцны хороололд амьдардаг 27601 (97.2%) өрхийн 26835 өрх нийтийн зориулалттай орон сууцанд, 761 (2.7%) өрх тусдаа тохилог орон сууцанд амьдарч байна.

Хүснэгт 18. Дүүргийн өрх, хороогоор, 2018 оны

Хороо	Нийт өрх	Үүнээс:						
		Орон сууцны хороололд			Гэр хороололд			
		Нийтийн орон сууц	Тусдаа тохилог орон сууц	Орон гэргүй	Тусдаа тохилог сууц	Сууцны тусдаа байшин	Монгол гэр	Орон гэргүй
Дүүргийн дүн	48940	26835	761	5	341	11277	9705	16
1-р хороо	2398	2394	4	-	-	-	-	-
2-р хороо	3371	3348	9	5	-	-	9	-
3-р хороо	4956	4800	149	-	-	-	7	-
4-р хороо	3737	1762	33	-	4	1081	854	3
5-р хороо	1462	-	-	-	-	965	497	-
6-р хороо	1929	-	-	-	22	1276	626	5
7-р хороо	1486	-	-	-	24	828	634	-
8-р хороо	3190	-	-	-	-	1615	1575	-
9-р хороо	2446	-	-	-	-	1128	1318	-
10-р хороо	3544	2273	6	-	-	837	428	-
11-р хороо	5100	3814	426	-	235	301	324	-
12-р хороо	1690	234	-	-	27	962	467	-
13-р хороо	1374	108	-	-	6	549	711	-
14-р хороо	1826	-	-	-	-	696	1126	4
15-р хороо	6825	6683	134	-	-	-	8	-
16-р хороо	3606	1419	-	-	23	1039	1121	4

Зураг 9. Дүүргийн өрх, сууцны төрлөөр



Гэр хороололд суурьшсан өрхийн тоо 2012 оноос 1967 өрхөөр нэмэгдэж, 2018 оны эцэст 21339 өрх болов. 2017 онтой харьцуулахад 140 (0.6%) өрх хасагдсан байна. Гэр хороололд суурьшсан 21339 (45.5%) өрхийн 9705 нь монгол гэрт, 11277 (52.8%) нь байшинд, 341 (1.6%) нь тохилог орон сууцанд, 16 (0.1%) өрх орон гэргүй амьдарч байна.

Зураг 10. Орон сууц, гэр хорооллын өрх хүн ам, орон гэргүй өрх



2018 онд нийт өрхөөс 21 (0.07%) өрхийн 35 хүн орон гэргүйн улмаас үрц овоохой, шатны хонгил зэрэг хүн амьдрах зориулалтын бүс сууцанд амьдарч байна. Үүнээс орон гэргүй 16 өрхийн 30 хүн гэр хороололд байна.




ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Ажиллах хүчний судалгааны дүнгээр тооцож гаргаснаар 2018 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 64924 байгаагаас 93.3 хувь нь ажиллагчид, 6.7 хувь нь ажилгүй иргэд байна. 2018 онд ажиллах хүчний судалгааны тооцоогоор ажилгүйдлийн түвшин 6.7 хувь байгаа нь өнгөрсөн оныхоос 3.8 пунктээр доогуур байна.

Хүснэгт 19. Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	87 334	93 345	102 916	114 655	122 876	119645
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	44 473	55 158	56 998	61 245	67 550	64924
Үүнээс: Ажиллагчдын тоо	43076	52 088	53 318	55 488	60 488	60556
Ажилгүй иргэдийн тоо	1397	3 070	3 680	5 757	7 062	4368
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	1 027	1 964	1 247	1 509	661	655
Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо	42 862	38 187	45 918	53 410	55 326	54721
Ажиллах хүчний оролцооны түвшин	50.9	59.1	55.4	53.4	55.0	54.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	49.3	55.8	51.8	48.4	49.2	50.6
Ажилгүйдлийн түвшин	3.1	5.6	6.5	9.4	10.5	6.7

Зураг 11. Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлт



Дүүргийн ажилгүйдлийн түвшин 2018 онд 6.7 байгаа нь эдийн засгийн идэвхтэй 100 хүн тутмын 7 нь ажилгүй байна гэсэн үг юм. Ажилгүйдлийн түвшинг хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин (8.8) эмэгтэйчүүдийнхээс (4.4) өндөр байна.

Хүснэгт 20. Ажиллагчдын тоо

	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийслэл	365 287	426 731	451 819	459 971	465 091	512 189	513053
Хан-Уул дүүрэг	33 478	43 076	52 088	53 318	55 488	60 488	60556
Нийслэлд эзлэх хувь	9.2	10.1	11.5	11.6	11.9	11.8	11.8

Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн 7 хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзсэн.

Хүснэгт 21. Ажилгүй иргэдийн тоо

	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийслэл	28 034	20 562	24 319	34 135	46 418	41 388	42294
Хан-Уул дүүрэг	3 170	1 397	3 070	3 680	5 757	7 062	4368
Нийслэлд эзлэх хувь	11.3	6.8	12.6	10.8	12.4	17.1	10.3

Ажилгүй иргэн гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

Зураг 12. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин




Хүснэгт 22. Ажиллагчдын тоо, насны бүлэг

Насны бүлэг	Нийслэл	Хан-Уул дүүрэг	Эзлэх хувь
Бүгд	513 053	60556	11.8
15-19	5 495	509	9.3
20-24	36 578	2 625	7.2
25-29	72 850	8 673	11.9
30-34	92 411	11 081	12.0
35-39	78 534	10 672	13.6
40-44	83 818	9 568	11.4
45-49	62 492	7 436	11.9
50-54	51 295	5 995	11.7
55-59	22 814	2 679	11.7
60-64	4 626	760	16.4
65-69	1 125	111	9.9
70 +	1 015	447	44.0

Хан-Уул дүүргийн хэмжээнд 2018 онд ажилгүй иргэдийг насны бүтцээр нь харахад ихэвчлэн залуучууд ажилгүйдэлд илүү өртөж байна.

Нийт ажил эрхлээгүй хүн амын 55.7 хувь нь 15-34 насныхан, 26.0 хувь нь ажиллах хүчинд шинээр орсон 20-24 насныхан байна. Ажилгүй иргэдийн 68.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 13. Нийт хүн амд эзлэх эдийн засгийн идэвхтэй хүн ам



Хүснэгт 23. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2014	2015	2016	2017	2018
Ажиллагчид, бүгд	52088	53318	55488	60488	60556
Бөөний, жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	8116	10379	11616	10790	12840
Барилга	6238	6443	5438	5470	4417
Боловсруулах үйлдвэр	6038	6135	6505	6916	7327
Боловсролын салбарын үйл ажиллагаа	5156	4008	3408	3709	5027
Зочид буудал, зоогийн газар	2705	3146	1128	2679	3443
Уул уурхай, олборлох үйлдвэр	1902	1453	1106	3564	2388
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	6430	5441	7523	6460	5505
Эрүүл мэнд, нийгмийн халамж	2205	2309	2130	2486	2293
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгал	3214	3143	4272	4923	3864
Цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамж	2118	1834	864	811	1235
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1715	1808	2876	3136	1693
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа	2474	2117	3381	4102	5321
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, ан агнуур	1671	2075	3209	1651	1233
Урлаг, үзвэр, тоглоом наадам, үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1674	2540	1875	3483	3424
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	276	-	73	91	203
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	156	487	84	217	343

Нийт ажиллагчдын 29321 (48.4%) нь эмэгтэй бөгөөд боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, боловсролын салбарт эмэгтэйчүүд, эрэгтэй ажиллагчдаас илүү байна.

Хүснэгт 24. Эдийн засгийн идэвхгүй хүн ам, шалтгаанаар

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Эдийн засгийн идэвхгүй хүн ам	33 767	42 862	38 187	45 918	53 410	55 326	54721
Гэрийн ажилтай	1 005	3 453	2 942	2 021	2 906	2 774	3109
Суралцдаг	9 935	12 227	12 589	13 682	17 845	15 905	16575
Сурахаар явах гэж байгаа	310	195	79	187	472	823	918
Тэтгэвэрт	9 631	11 121	10 997	14 781	13 802	15 707	15159
Өндөр настан	1 438	2 183	365	245	1 261	-	284
Хөгжлийн бэрхшээлтэй	3 313	3 747	3 812	3 618	4 228	6 084	4003
Ажил хийхийг хүсээгүй	1 015	2 049	356	529	1 090	359	179
Хүүхэд асарсан	3 873	4 092	3 404	6 265	7 782	8 467	10210
Өвчтэй байсан	817	1 354	530	1 096	558	807	1347
Өвчтөн, өндөр настан асарсан	479	732	406	580	708	852	1119
Бусад	1 951	1 709	2 707	2 914	2 758	3 548	1818

Хан-Уул дүүргийн эдийн засгийн идэвхгүй хүн амын 5.7 хувь нь гэрийн ажилтай, 30.3 хувь нь суралцдаг, 1.7 хувь нь сурахаар явах гэж байгаа, 7.3 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 18.7 хувь нь хүүхэд асарсан, 36.3 хувь нь бусад шалтгааны улмаас хөдөлмөр эрхлээгүй байна.


Хүснэгт 25. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо

	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Нийслэл	12 811	14 143	15 787	12 640	11 988	7 043	8276
Хан-Уул дүүрэг	919	1 027	1 964	1 247	1 509	661	655
Нийслэлд эзлэх хувь	7.2	7.3	12.4	9.9	12.6	9.4	7.9

Хүснэгт 26. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо

Боловсролын түвшин	2014		2015		2016		2017		2018	
	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм
Бүртгэлтэй ажилгүй иргэд, бүгд	1964	1042	1247	605	1509	733	661	387	655	316
Дээд боловсролтой	781	538	587	347	804	443	348	231	286	176
Тусгай дунд боловсролтой	122	55	75	31	83	33	30	14	38	13
Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв төгссөн	97	46	52	16	75	30	10	4	16	8
Боловсролгүй	964	403	533	211	547	227	273	138	315	119

Зураг 14. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр



Хүснэгт 27. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, насны бүлгээр

Насны бүлэг	2014		2015		2016		2017		2018	
	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм	бүгд	эм
15-24	449	250	244	134	265	129	99	60	128	30
25-34	739	413	479	229	556	262	304	181	250	142
35-44	386	211	289	146	386	201	162	90	162	87
45-59	282	130	225	92	294	139	93	56	107	55
60 +	108	38	10	4	8	2	3	0	8	2



НИЙГМИЙН ДААТГАЛ

2018 онд Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 3594 байгууллагын нийт 141.0 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн байна. Тэдгээрийн 82.4 мянга (58.4%) нь ААНБ-ын, 12.2 мянга (8.6%) нь төсвийн байгууллагын, 9.8 мянга (7.0%) нь сайн дурын даатгуулагчид, 36.6 мянга (26.0%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 28. Нийгмийн даатгалаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Нийт байгууллагын тоо	2431	2744	2982	3172	3594
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	2316	2627	2863	3050	3469
Төсөвт байгууллагын тоо	115	117	119	122	125
Нийт даатгуулагчдын тоо	166974	165425	168070	195327	141035
ААНБ-ын даатгуулагчийн тоо	59012	57559	59397	69388	82412
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	10897	10593	10783	11664	12211
Сайн дурын даатгуулагчийн тоо	8088	8856	9364	9948	9827
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	88977	88417	88526	104327	36585

2018 онд дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 189.3 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 30.1 тэрбум төгрөгөөр илүү бүрдсэн буюу 18.9 хувиар давж биелсэн байна.


Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх онтой харьцуулахад 12.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 29. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт, сан тус бүрээр, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2017	2018	2017	2018	2017	2018
Дүүргийн дүн	133 995.6	159 159.4	143 170.8	189 305.0	106.8	118.9
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	83 536.4	101 275.5	91 786.8	121 707.7	109.9	120.2
Тэтгэмжийн сангийн орлого	10 236.9	11 389.8	10 494.4	15 672.3	102.5	137.6
ҮОМШӨ-ний даатгалын орлого	11 419.4	10 137.2	12 298.4	14 692.0	107.7	144.9
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	2 481	2 350.1	2 534.1	3 226.2	102.1	137.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	26 321.9	34 006.8	26 057.1	34 006.8	99.0	100.0

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 64.3 хувийг тэтгэврийн даатгалын санд, 8.3 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 7.7 хувийг ҮОМШӨ-ий даатгалын санд, 1.7 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 18.0 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 15. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого сан тус бүрээр, хувиар



Зураг 16. Нийгмийн даатгалын сангийн зардал, хувиар




Хүснэгт 30. Нийгмийн даатгалын сангийн орлого, зардал, сая төгрөг

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Нийгмийн даатгалын сангийн орлого	97 904.9	100 073.2	113 312.4	143 170.8	189 305.0
Нийгмийн даатгалын сангийн зардал	98 424.9	103 797.8	122 159.8	143 728.2	189 849.9
Үүнээс:					
Тэтгэврийн даатгал	62 736.5	65 442.7	79 243.6	90 197.5	121 098.6
Тэтгэмжийн даатгал	7 022.2	7 951.0	8 903.3	11 083.7	16 089.7
ҮОМШӨ-ний даатгал	8 742.6	8 766.4	9 480.8	1 076.4	14 882.2
Ажилгүйдлийн даатгал	1 790.9	2 628.5	3 120.0	3 660.4	4 149.2
Эрүүл мэндийн даатгал	18 132.7	19 009.2	21 412.1	28 022.6	33 630.2

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 63.8 хувийг тэтгэврийн, 8.5 хувийг тэтгэмжийн, 7.8 хувийг ҮОМШӨ-ий, 2.2 хувийг ажилгүйдлийн 17.7 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 17. Даатгалын сангийн орлого, зардал, сая төгрөг



Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 13720 хүнд 2.0 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 4823 хүнд 7.6 тэрбум төгрөгийг, оршуулгын тэтгэмжид 54 хүнд 54.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

ҮОМШӨ-ий даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 158 хүнд 942.8 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 91.8 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 133 хүнд 108.2 сая төгрөг, ҮОМШӨ-ний сувиллын зардлын сангаас 36 хүнд 5.4 сая төгрөгийг төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авсан 1832 хүнд 3.6 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын таван төрлийн сангаас 189.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардлыг санхүүжүүлж, давхардсан тоогоор 141.0 мянга гаруй иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлсэн байна. Зарцуулсан хөрөнгийн хэмжээ 2017 оны мөн үеэс 46.1 тэрбум төгрөгөөр буюу 32.1 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 31. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, сая төгрөг

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018
Олгосон тэтгэврийн хэмжээ	62736.5	65442.7	79243.6	90197.5	121098.6
Өндөр насны тэтгэвэр	36179.2	44029.5	50837.3	57386.0	67580.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	5890.2	7027.7	7773.1	8280.8	9553.1
Тэжээгчээ алдсаны	1761.1	1956.4	2150.6	2293.9	2580.3
Цэргийн тэтгэвэр	5025.2	5668.8	6243.9	6730.1	7937.7
Бусад зарлага	13880.8	6760.3	12238.7	15506.7	33447.5


Нийт олгосон тэтгэврийн 55.8 хувийг өндөр насны, 7.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.1 хувийг тэжээгчээ алдсаны, 6.6 хувийг цэргийн, 27.6 хувийг бусад зарлагад тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 32. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Тэтгэвэр авагчдын тоо	13396	13866	15210	16424	17594	18779	20252
Үүнээс:							
Өндөр насны тэтгэвэр	9237	9630	10717	11610	12588	13633	14567
Тахир дутуугийн	2292	2359	2613	2783	2862	2962	3051
Тэжээгчээ алдсаны	765	742	741	749	776	796	817
Цэргийн тэтгэвэр	888	918	936	975	1018	1074	1129
ҮОМШӨ-ий	214	217	203	307	350	314	344

Тэтгэврийн даатгалыг төрлөөр нь авч үзвэл, өндөр насны тэтгэвэр авагч 14567 хүнд 67.6 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3051 хүнд 9.5 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 817 хүнд 2.6 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1129 хүнд 7.9 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Зураг 18. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, 2018 он /хувиар/




БОЛОВСРОЛ

Сургуулийн өмнөх боловсрол: 2018-2019 оны хичээлийн жилд Нийслэлийн хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын 672 байгууллага үйл ажиллагаа явуулж байснаас 118 (17.5%) нь Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байршин үйлчилгээ үзүүлж байна. Үүнээс: 29 нь төрийн өмчийн, 89 нь хувийн цэцэрлэг байна. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 118 цэцэрлэгийн үндсэн бүлэгт 17653 хүүхэд хамрагдан хүмүүжиж байгаа бөгөөд өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 1548-аар өссөн байна. Нийт 1279 ажилчдаас 594 (46.4%) нь үндсэн багш (үүнээс: 96.8 хувь нь эмэгтэй), 526 (41.1%) нь туслах багш (үүнээс: 99.6 хувь нь эмэгтэй) байна.


Хүснэгт 33. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
СӨБ-ын байгууллагын тоо	76	88	108	112	118
СӨБ-д хамрагчдын тоо	9638	11520	14048	16105	17653
Үндсэн багшийн тоо	317	383	497	561	594

Зураг 19. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо



Зураг 20. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдагчид



2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт 84.9 хувьтай байна. Нийт СӨББ-д хамрагдагчдын 8663 нь эмэгтэй хүүхэд байна.

Хүснэгт 34. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын бүлгийн тоо, 2018/2019 онд

	Бүлгийн тоо	Үүнээс:										
		Цэцэрлэгийн	Үүнээс:						Хувилбарт сургалтын	Үүнээс:		
			Ясли	Бага	Дунд	Ахлах	Бэлтгэл	Холимог		Ээлжийн	Нүүдлийн	Явуулын
Бүгд	552	552	-	110	129	134	148	31	-	-	-	-
Төрийн өмчийн	225	225	-	46	50	61	66	2	-	-	-	-
Төрийн өмчийн бус	327	327	-	64	79	73	82	29	-	-	-	-

Зураг 21. СӨББ-д ажилладаг үндсэн багшийн тоо



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт 594 үндсэн багш ажиллаж байгаагаас 69 (11.6%) багш нь 50-60+ насны багш, 136 (22.9%) багш нь 40-49 насны багш, 145 (24.4%) нь 30-39 насны багш, 244 (41.1%) багш нь 30 хүртэлх насны багш эзэлж байна. Хан-Уул дүүргийн СӨББ-ийн үндсэн нэг багшид 30 хүүхэд ногдож байна.


Бага, дунд боловсрол: 2018-2019 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 37 сургуульд 30766 хүүхэд суралцаж байгаагаас эмэгтэй 15210 хүүхэд суралцаж байна. Өнгөрсөн оны хичээлийн жилтэй харьцуулахад суралцагчдын тоо 2667 (9.5%) хүүхдээр нэмэгдсэн байна.

2018-2019 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуульд нийт 4280 хүүхэд 1-р ангид шинээр ангид элсэн орсон нь өнгөрсөн оныхтой харьцуулвал 406 (10.5%) хүүхдээр өссөн байна. 1-р ангид шинээр элсэн орсон нийт хүүхдийн 2079 (48.6%) нь эмэгтэй хүүхэд байна.


Хүснэгт 35. Ерөнхий боловсролын сургуулийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
ЕБС-ийн тоо	22	29	33	35	37
Суралцагчдын тоо	18878	22741	25383	28099	30766
Үндсэн багшийн тоо	991	1191	1254	1389	1459

Зураг 22. ЕБС-ийн тоо, төрийн бус сургуулийн тоо




Зураг 23. ЕБС-д суралцагчдын тоо, эмэгтэй




Сүүлийн жилүүдэд Хан-Уул дүүрэгт хүн ам шилжин ирэх хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотой дүүргийн ЕБС-д суралцагчдын тоо жил ирэх тусам өсч байна. 2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-д суралцагчдын тоо өмнөх оноос 2667 (9.5%) хүүхдээр өссөн байна. Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчдын 18335 хүүхэд I-V анги, 8685 нь VI-IX анги, 3746 хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.

Зураг 24. ЕБС-ийн үндсэн багшийн тоо, сургуулийн өмчийн төрлөөр




2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-д ажиллаж байгаа үндсэн багш 1459 байгаагаас 1047 нь төрийн өмчийн сургуульд, 412 нь төрийн бус өмчийн сургуульд ажиллаж байна. Үндсэн багшийн тоо өмнөх онтой харьцуулахад 268 (22.5%)-аар өссөн байна. Хан-Уул дүүргийн ЕБС-ийн нэг үндсэн багшид 21 хүүхэд ногдож байна.

Зураг 25 . ЕБС-ийн үндсэн багшийн боловсролын түвшин




Багш нарын боловсролын мэргэжил дээшлүүлсэн байдлыг авч үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилд нийт үндсэн багш нарын 0.1 хувь нь доктор, 13.8 хувь нь магистр, 71.5 хувь нь бакалавр, 10.4 хувь нь дипломын боловсролтой багш нар тус тус эзэлж байна. Мөн СӨБ-ын үндсэн багш нарын 538 (90.6%) нь мэргэжлийн зэрэгтэй байгаа бөгөөд 1.5 хувь нь зөвлөх, 28.8 хувь нь тэргүүлэх, 69.7 хувь нь заах арга зүйч зэрэгтэй байна.

Зураг 26. ЕБС болон СӨББ-ын үндсэн багш нарын мэргэжлийн зэрэг



Зураг 27. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш нарын мэргэжил дээшлүүлсэн байдал



2018-2019 оны хичээлийн жилд үндэсний сургагч багш 320, орон нутгийн сургагч багш 1200, бүсийн хэмжээнд 200 багш нар мэргэжил дээшлүүлсэн байна.



ЭРҮҮЛ МЭНД

2018 онд Хан-Уул дүүргийн хэмжээнд нийт 70 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын 489 их эмч нар иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж ажиллажээ.

Хүснэгт 36. Дүүргийн эрүүл мэндийн салбарын үзүүлэлт, 2009-2018 он


Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Эрүүл мэндийн байгууллага	4	7	7	7	7	7	5	5	5	4
Эрүүл мэндийн нэгдэл	1	1	1	1	1	1	1	1	1	1
Өрхийн эмнэлэг	13	13	13	14	14	14	15	15	15	15
Эмнэлэгийн орны тоо	224	846	846	846	856	968	968	974	974	1076
Их эмчийн тоо	127	211	211	186	192	344	352	367	367	489
Хувийн эмнэлэг	14	29	29	25	27	33	39	41	41	50
Эмийн сан	44	39	39	39	39	58	61	60	81	88

2018 оны байдлаар эмнэлэгт үзүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 757038 болж, өмнөх оноос үзлэгийн тоо 24465 буюу 3.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 37. Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

Он	Эмнэлэгийн үзлэгийн тоо	Төрөлт	Төрөхийн улмаас эндсэн эх	Амьд төрсөн нярай	Нас баралт	Үүнээс: 0-1 нас
2009	591809	2515	0	2533	538	29
2010	647013	2617	2	2631	608	33
2011	693969	2991	1	2995	642	22
2012	731511	3377	3	3407	649	37
2013	779552	3712	5	3737	602	48
2014	779424	4044	3	4091	704	45
2015	789734	4487	1	4510	610	41
2016	778441	4586	2	4613	693	44
2017	781503	4369	1	4400	665	44
2018	757038	4635	0	4661	766	47

Зураг 28. Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд



Дүүргийн хэмжээнд нэг хүртэл насны хүүхдийн эндэгдэл 2018 оны байдлаар 47, эхийн эндэгдэлгүй гарчээ. Төрөлт 2018 оны байдлаар 4635 болж, өмнөх оноос 266 (6.1%) төрөлтөөр нэмэгдсэн байна. Амьд төрсөн нярайн тоо 2018 онд 4661 байгаа нь өмнөх оноос 261 (5.9%) хүүхдээр нэмэгдсэн байна.

2018 онд халдварт өвчнөөр өвчилсөн 2056 тохиолдол бүртгэгдсэн нь 2017 оноос 330 (13.8%) тохиолдлоор, 2016 оноос 1291 (38.6%) тохиолдлоор тус тус буурсан байна.

Хүснэгт 38. Бүртгэгдсэн халдварт өвчний гаралт, өвчний төрлөөр

Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Халдварт өвчин	1024	985	1467	2155	1265	1200	3123	3347	2386	2056
Үүнээс:										
Вируст гепатит	190	138	515	289	93	64	35	27	29	28
Улаан бүрхан	-	-	-	-	-	-	1643	1366	1	-
Гахайн хавдар	92	13	70	715	142	19	17	25	14	31
Менингит	2	-	1	-	1	2	-	1	-	-
Сүрьеэ	226	246	200	202	216	231	267	267	253	223
Заг хүйтэн	60	41	67	37	33	21	50	48	35	43
Цусан суулга	216	218	143	177	149	172	208	258	375	555
Тэмбүү	79	91	170	136	136	219	196	120	118	91
Бусад	159	238	301	599	495	472	707	1235	1561	1085

2018 оны халдварт өвчнөөр өвчлөгчдийн бууралтад бусад халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 476 (30.5%) тохиолдлоор буурсан нь нөлөөлжээ. Харин 2018 онд вируст гепатит өвчнөөр өвчилсөн тохиолдлын тоо 28 байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 1 (3.4%) тохиолдлоор буурч, 2016 онтой харьцуулахад 1 (3.7%) тохиолдлоор өссөн байна.

Хүснэгт 39. Бүртгэгдсэн халдварт өвчний гаралт, өвчний төрлөөр, хороогоор 2018 он

Үзүүлэлт	Хороо																	Нийт халдварт өвчин
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	харьяаллын бус	
Вируст гепатит	3	3	6	5	2			1		1	1	3			2	1		28
Цусан суулга	26	36	50	50	15	20	16	29	36	41	51	27	13	17	72	49	7	555
Улаан эсэргэнэ	5	9	11	7	2	4	2	6	2	12	13		1	2	24	2		102
Сальмонеллөз	3	3	2	1	1	3			1	1	1	4	1	4	4	1		30
Салхин цэцэг	30	35	80	54	4	20	20	11	26	56	87	7	8	8	127	47	4	624
Гахайн хавдар	4	2	3	1	2	1	1		2	1	3	2	3	1	4	1		31
Ёлом		2							2	3	1			1				9
Гар хөл, амны өвчин	9	15	22	20	10	4	4	6	9	8	24	4	4	3	35	12		189
Тэмбүү	2	4	7	3	7	2	2	8	6	9	7	7	5	6	6	4	6	91
Заг хүйтэн	3	2	4	3	1	1	1	4	2	5	2	2	3	3	3	3	1	43
Трихомониаз		2	3	3	5	1	2	9	8	8		2	2	5	1	8	1	60
Шинээр илэрсэн сүрьеэ	10	20	31	23	14	12	12	14	10	11	16	10	6	3	14	17		223
Мөөгөнцөр			1											1				2
Хоолны хордлого	2	8	4	4		3	2		2	1	1	2	1		24	2	1	57
Бусад өвчлөл				1				1		1	1	3		2	1		2	12
Дүн	97	141	224	175	63	71	62	89	106	158	208	73	47	56	317	147	22	2056

2018 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн 317 нь (15.4%) 15-р хороонд, 224 нь (10.9%) 3-р хороонд, 208 нь (10.1%) 11-р хороонд, 175 нь (8.5%) 4-р хороонд, 158 нь (7.7%) 10-р хороонд, 147 нь (7.1%) 16-р хороонд, 141 нь (6.9%) 2-р хороонд, 106 нь (5.2%) 9-р хороонд, 580 нь (28.2%) бусад хороонд бүртгэгдсэн байна.

Зураг 29. Халдварт өвчин, хороогоор 2018 он



Зураг 30. Халдварт өвчин, вирус хепатит, 2009-2018 он



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2018 онд 2332 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 22.7 хувь буюу 432 хэргээр өсжээ. Гэмт хэргийн илрүүлэлт 31.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 2.4 пунктээр өссөн байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1889 (81.0%) нь хөнгөн, 443 (19.0%) хувь нь хүнд гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


Хүснэгт 40. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо, хэргийн ангилал, төрөл

Хэргийн төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	өөрчлөлт /+, -/	2018 2017
Бүртгэгдсэн хэрэг- Бүгд	1236	1496	1390	1639	1900	2332	432	22.7
Гэмт хэргийн ангиллаар								
Хөнгөн	541	692	702	854	1221	1889	668	54.7
Хүндэвтэр	586	666	568	654	277	0	-277	-100
Хүнд	87	98	72	82	386	443	57	14.8
Онц хүнд	22	40	48	49	16	0	-16	-100
Гэмт хэргийн төрлөөр								
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг								
Үүнээс:								
Хүнийг санаатай алах	13	14	11	5	7	6	-1	-14.3
Бусдын бие махбодид гэмтэл учруулах	392	446	450	524	533	616	83	15.6
Бусдыг амиа хорлоход хүргэх	8	14	13	13	37	36	-1	-2.7
Өмчлөх эрхийн гэмт хэрэг								
Үүнээс:								
Хулгай	355	403	365	461	645	713	68	10.5
Дээрэм	32	39	17	30	51	62	11	21.6
Булаалт	11	17	9	6	3	-	-3	-100
Малын хулгай						17	17	
Залилан	51	103	131	190	196	442	246	1.2*
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг								
Үүнээс:								
Хүчиндэх	8	11	11	11	19	17	-2	-10.5
Танхайрах	99	90	77	98	47	3	-44	-93.6
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	114	137	107	90	88	79	-9	-10.2
Бусад	153	222	199	214	274	341	67	24.5

Эх үүсвэр: ХУД-ийн Цагдаагийн хэлтсийн мэдээ

2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 2017 оны мөн үетэй харьцуулахад ББМБГУ 15.6 хувь, залилан 1.2 дахин, дээрэм 21.6 хувь, хулгай 10.5 хувь, бусад хэрэг 24.5 хувиар өсөж, хүнийг санаатай алах 14.3 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх 2.7 хувь, хүчин 10.5 хувь, ТХХАБАЖЭ 10.2 хувь, танхай 93.6 хувиар тус тус буурсан байна.

Зураг 31. Бүртгэгдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн ангиллаар



Хүснэгт 41. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо, хороодоор

Хороо	2013	2014	2015	2016	2017	2018	үүнээс:		илрүүлэлт хувь
							эзэнгүй	ял сонсгосон	
1	95	90	82	89	103	116	115	23	20.0
2	111	187	136	186	200	229	225	53	23.6
3	164	182	214	201	207	311	303	80	26.4
4	81	115	86	126	151	205	194	75	38.7
5	35	48	43	39	45	62	61	30	49.2
6	47	32	31	23	52	54	51	20	39.2
7	28	31	22	30	42	36	36	14	38.9
8	69	59	54	63	80	89	87	37	42.5
9	72	70	59	60	62	78	76	35	46.1
10	83	127	96	151	165	198	181	74	40.9
11	153	182	182	191	240	300	292	88	30.1
12	39	53	45	49	67	72	70	24	34.3
13	30	29	34	29	52	48	47	25	53.2
14	47	49	49	52	67	88	88	28	31.8
15	144	190	196	272	274	344	336	68	20.2
16	38	52	61	78	93	102	100	44	44.0
Бүгд	1236	1496	1390	1639	1900	2332	2262	718	31.7


Дүүргийн хэмжээнд гарсан гэмт хэргийн тоог хороогоор авч үзвэл: өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 1-6, 8-12, 14-16 хороодод гэмт хэргийн гаралт өссөн ба 7, 13-р хороодод гэмт хэрэг буурсан байна. 2018 онд гарсан нийт гэмт хэргээс эзэн тодорхойгүй 97.0 хувь, ял сонсгосон 30.8 хувь, нийт гэмт хэргийн илрүүлэлт 31.7 хувьтай байна.

Хүснэгт 42. Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоо, дүүргээр, улс, нийслэлээр

Хэргийн төрөл	2013	2014	2015	2016	2017	2018
Багануур	278	236	311	293	254	253
Багахангай	31	25	21	23	31	24
Баянгол	2521	2813	2951	3137	3204	4501
Баянзүрх	3742	4267	4272	4218	5939	7522
Налайх	302	339	423	489	393	420
Сонгинохайрхан	2778	3042	3232	2811	3691	3692
Сүхбаатар	2416	2594	3085	2962	3816	4132
Чингэлтэй	2115	2393	2254	2337	2719	2776
Хан-Уул	1236	1496	1390	1639	1900	2332
Нийслэлийн дүн	15419	17205	17939	17909	21947	25652
Улсын дүн	25362	27318	27757	27167	32259	36220
Нийслэлд эзлэх хувь	8.0	8.7	7.7	9.2	8.7	9.0
Улсад эзлэх хувь	4.9	5.5	5.0	6.0	5.9	6.4

Дүүргийн хэмжээнд гэмт хэрэг гаралтын байдал өнгөрсөн оноос 22.7 хувиар өссөн байна. Нийслэлийн төвийн 6 дүүрэгтэй харьцуулахад хамгийн бага буюу 2018 оны байдлаар бүртгэгдсэн гэмт хэрэг улсын хэмжээнд 6.4 хувь, нийслэлийн хэмжээнд 9.0 хувь нь Хан-Уул дүүрэгт бүртгэгджээ. Өнгөрсөн оноос нийслэлийн дүнд эзлэх хувийн жин 0.3 пунктээр, улсын дүнд эзлэх хувийн жин 0.5 пунктээр түс түс өссөн байна.

Зураг 32. Гэмт хэрэг, эзэн тодорхойгүй ба ял сонгосон байдал, хороодоор, 2018 он



Хүснэгт 43. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, төрлөөр


Хэргийн төрөл	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	1236	1496	1390	1639	1900	2332
Учрал	8	14	13	13	37	36
Хүн амь	13	14	11	5	7	6
Хүчин	8	11	11	11	19	17
ИЧЭМЭ*	392	446	450	524	533	616
Танхай	99	90	77	95	47	3
Дээрэм	32	39	17	30	51	62
Булаалт	11	17	9	6	3	-
Малын хулгай	-	-	-	-	-	17
Залилан	51	103	131	190	196	442
Хулгай	355	403	365	461	645	713
ТХХАБАЖЭ*	114	137	107	90	88	79
Бусад	153	222	199	214	274	341

*Тайлбар: ИЧЭМЭ- Иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг

ТХХАБАЖЭ- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг

2018 оны байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 1.5 хувийг учрал, 0.3 хувийг хүн амь, 0.7 хувийг хүчин, 26.4 хувийг ИЧЭМЭ, 0.1 хувийг танхай, 2.7 хувийг дээрэм, 0.7 малын хулгай, 19.0 хувийг залилан, 30.6 хувийг хулгай, 3.4 хувийг ТХХАБАЖЭ, 14.6 хувийг бусад хэргүүд тус тус эзэлж байна.

Зураг 33. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, хулгайн гэмт хэрэг




Хүснэгт 44. Илрээгүй гэмт хэрэг, илрүүлэлт


Он	Илрээгүй гэмт хэрэг	Илрүүлэлтийн хувь
2014	272	59.5
2015	222	63.0
2016	275	65.4
2017	1001	29.3
2018	1544	31.7

Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь өмнөх оноос 2.4 пунктээр өссөн байхад 2014 оноос 27.8 пунктээр буурсан байна. Жил ирэх тутам гэмт хэрэг гаралт нэмэгдсээр байгаа нь илрээгүй гэмт хэргийн тоог өсөхөд хүрч байна.

Зураг 34. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр



Зураг 35. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр



Хүснэгт 45. Гэмт хэрэг үйлдэгсдэд эмэгтэй хүн, хүүхэд оролцсон байдал

Хан-Уул	Нийт хүн	үүнээс: эмэгтэй	Хүүхэд
2013	1115	170	64
2014	1284	212	67
2015	1253	219	83
2016	1462	251	73
2017	994	137	57
2018	849	114	45
Нийслэлийн дүн	8844	1426	495
Улсын дүн	16389	2218	956
Нийслэлийн дүнд эзлэх хувь	9.6	8.0	9.1
Улсын дүнд эзлэх хувь	5.2	5.1	4.7

2018 оны байдлаар 849 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 13.4 хувь нь эмэгтэй, 5.3 хувь нь хүүхэд байна. Дүүргийн гэмт хэрэг үйлдэгсэдийн дүнг нийслэлийн гэмт хэргийн дүнтэй харьцуулахад 8.0 хувь нь эмэгтэй, 9.1 хувь нь хүүхэд, улсын гэмт хэргийн дүнтэй харьцуулахад 5.1 хувь нь эмэгтэй, 4.7 хувь нь хүүхэд байна.

Хүснэгт 46. Гэмт хэрэг үйлдэгсэд, насны ангиллаар

Хан-Уул	15 хүртэлх	16-17	18-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70-ба түүнээс
2013	11	53	309	214	151	123	94	87	44	15	11	3	-
2014	11	56	315	252	222	145	113	78	59	24	9	-	-
2015	24	59	273	249	195	160	93	94	66	26	10	4	-
2016	27	46	303	351	226	181	145	88	60	19	13	3	-
2017	9	48	243	197	152	123	80	70	40	21	5	3	3
2018	22	23	195	193	146	98	73	49	24	16	5	2	3
Нийслэлийн дүн	208	287	2070	1799	1584	942	820	596	283	158	63	21	13
Улсын дүн	426	530	3500	3305	2854	1940	1628	1128	574	320	121	40	23
Нийслэлийн дүнд эзлэх хувь	10.6	8.0	9.4	10.7	9.2	10.4	8.9	8.2	8.5	10.1	7.9	9.5	23.1
Улсын дүнд эзлэх хувь	5.2	4.3	5.6	5.8	5.1	5.1	4.5	4.3	4.2	5.0	4.1	5.0	13.0

2018 оны гэмт хэрэг үйлдэгсэдийг насны ангиллаар авч үзвэл, 23.0 хувийг 18-24 насны, 22.7 хувийг 25-29 насны, 17.2 хувийг 30-34 насны, 11.5 хувийг 35-39 насны, 8.6 хувийг 40-44 насны, 5.8 хувийг 45-49 насныхан хамгийн өндөр буюу гэмт хэрэгт их холбогддог байна. Өнгөрсөн онтой харьцуулахад гэмт хэрэг үйлдэгсдийн 15 хүртэлх насны 2.4 дахин өссөн байхад бусад насны гэмт хэрэг үйлдэгсэд 2.0-52.0 хувиар буурчээ.

Хүснэгт 47. Гэмт хэрэг үйлдэгсэд, нийгмийн байдлаар

Хан-Уул	Нийгмийн байдлаар											
	Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Хугацаат цэргийн алба хаагч	Сургууль завсардсан хүүхэд	Тэнэмэл	Хоригдол	Ажилгүй
2012	41	300	13	83	5	62	18	-	4	7	-	500
2013	47	299	18	132	22	72	14	-	7	1	2	501
2014	66	249	39	232	28	81	22	1	3	6	6	551
2015	53	247	41	249	8	62	30	1	3	9	2	548
2016	50	202	30	316	12	65	32	-	-	5	-	750
2017	35	92	17	187	5	53	13	-	1	18	1	572
2018	13	93	15	163	2	33	20	-	1	2	3	504
Нийслэлийн дүн	193	715	178	1818	70	278	226	4	9	68	29	5256
Нийслэлийн дүнд эзлэх хувь	6.7	13.0	8.4	9.0	2.8	11.9	8.8	-	11.1	2.9	10.3	9.6

Гэмт хэрэг үйлдэгсэдийг нийгмийн байдлаар нь авч үзвэл 59.4 хувь нь ажилгүй, 32.0 хувь нь ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 0.2 хувь нь малчин, 6.2 хувь нь оюутан, сурагч, 1.5 хувь нь төрийн албан хаагч, сургууль завсардсан 0.1 хувь, хоригдол 0.4 хувь, 0.2 хувь нь тэнэмэл иргэд байна. Гэмт хэрэгт холбогдсон байдлаараа 163 хүн (19.2%) хувиараа хөдөлмөр эрхлэгчид шалгагдсан байна.

